



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/19.

Номгон

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгох тухай

ГХГЗЗ Газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 10 дугаар зүйлийн 10.17 дахь заалт, Засгийн газрын 2003 оны 205 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Номгон 1-р баг Баян-Ойт Цогцолбор сургуулийн баруун талд байрлах Аймгийн нийтийн номын сангийн 0178972 дугаартай Газар эзэмших эрхийн гэрчилгээг үрэгдүүлсэн тул гэрчилгээг хүчингүй болгосугай.
2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосонтой холбогдуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг нөхөн олгохыг Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн /С.Должинсүрэн/-д даалгасугай.
3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонтой холбогдуулан олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлаж холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг Мэдээлэл технологийн асуудал хариуцсан ажилтан /Ч.Анхбаяр/-т даалгасугай.
4. Үрэгдүүлсэн Газар эзэмших эрхийн гэрчилгээний үнийг 1,5 дахин нэмэгдүүлж төлөхийг аймгийн Нийтийн номын сангийн Захирал /Б.Түвшинчимэг/-т даалгасугай.

ДАРГА

Т.НОРОВ